

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2023 оны дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТУШААХ нь**:

1. “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан журмыг орон нутгийн засаг захиргааны байгууллага, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлж, мөрдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар /..... /-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Чинзориг/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/150 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДАЛ ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн (цаашид “хохирогч” гэх) амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг түр хамгаалах байранд байрлуулж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардал (цаашид “хувьсах зардал” гэх)-аар тооцож санхүүжүүлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Хувьсах зардал нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-т заасан аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ болон нийгмийн ажлын үйлчилгээ хамаарна.

1.3. Энэхүү журмаар зохицуулах зардал тооцох, санхүүжилт олгох, бичиг баримт бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг түр хамгаалах байрыг үүсгэн байгуулагчийн өмчийн хэлбэрээс үл хамааран санхүүжилт олгох төрийн байгууллагууд (аймаг, нийслэл, дүүрэг дэх гэр бүл, хүүхэд хамгааллын болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан) үйл ажиллагаандаа нэгэн адил мөрдөнө.

1.4. Энэхүү журмыг хохирогчийг түр байрлуулах ор, гал тогоо бүхий Нэг цэгийн үйлчилгээний төвд жишиг болгон мөрдөж болно.

Хоёр. Хувьсах зардлын норматив, түүний бүрэлдэхүүн

2.1. Нэг хүнд ногдох хувьсах зардал нь дараах бараа, үйлчилгээнээс бүрдэнэ:

- 2.1.1. хоол хүнс;
- 2.1.2. хувцас, ариун цэврийн хэрэгсэл;
- 2.1.3. нийгмийн ажлын үйлчилгээ.

2.2. Хувьсах зардлыг энэхүү журмын хавсралтад заасан “Түр хамгаалах байранд байрлах нэг хүнд ногдох хувьсах зардлын норматив”-ын дагуу дараах байдлаар тооцно:

2.2.1. хоол хүнсний зардлыг Түр хамгаалах байр болон Нэг цэгийн үйлчилгээний төвд байрласан хүний хоногийн тоогоор үржүүлж тооцно. Хоол хүнсний зардал нь “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын хавсралтаар баталсан жишгийн дагуу насанд хүрсэн хүний өдөрт авах илчлэг, орц, нормыг хангахуйц өглөөний цай, өдөр, оройн хоолны материалын өртөг байна.

2.2.2. түр хамгаалах байранд байрласан хохирогчид хувийн ариун цэвэр сахихад шаардлагатай нэг удаагийн багц олгох ба энэ нь хүний 14 хоногийн хэрэгцээг хангах боломжтой байна. Багцад шүдний оо, сойз, гар нүүрийн алчуур, гарын болон эдийн саван, шампунь, ариун цэврийн цаас, эмэгтэйчүүдийн ариун

хэрэгсэл, дотуур хувцас (дотуур өмд, майк, оймс) багтана. Түр хамгаалах байранд байрласан хүний цагаан хэрэглэлийн ариутгалын зардал, эмнэлгийн анхан шатны яаралтай тусламж үзүүлэхэд хэрэглэх өвчин намдаах эм, ороох боох материал, ариутгалын бодисыг багцад нэмж хамруулна. Багцыг насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүн болон охид, хөвгүүдийн онцлогт нийцүүлж, төрөлжүүлэн бэлтгэсэн байна.

2.2.3. ариун цэврийн багцыг хохирогч хэд хоног байрласнаас үл хамааран нэг удаа олгох боловч энэ нь дээд тал нь хүний 14 хоногийн хэрэглээ гэж тооцно. Хэрэв хохирогч 14 хоногоос дээш хугацаанд байрласан бол нормативт зардлыг нэмэгдсэн хоногийн тоогоор хувь тэнцүүлэн нэмж тооцно.

2.2.4. нийгмийн ажлын үйлчилгээнд дараах зүйлс хамаарна:

- 2.2.4.1. нөхцөл байдлын үнэлгээ хийх;
- 2.2.4.2. холбон зуучлах;
- 2.2.4.3. сургалтад хамруулах, чадавхжуулах;
- 2.2.4.4. хүүхдийг боловсролд хамруулах, хичээлийн хоцрогдол арилгах, хичээлийн хэрэгслээр хангах;
- 2.2.4.5. бичиг баримтжуулах;
- 2.2.4.6. зөвлөгөө өгөх;
- 2.2.4.7. гэр бүлд нь эргэн нэгтгэх;
- 2.2.4.8. аюулгүй унаагаар үйлчлэх;
- 2.2.4.9. эрүүл мэндийн тусламж үзүүлэх;
- 2.2.4.10. шаардлагатай бусад үйлчилгээ.

2.2.5. нийгмийн ажлын үйлчилгээг хохирогчид чиглэсэн төлөвлөгөөнд үндэслэн аль тохирохыг хэрэгжүүлэх бөгөөд нормативт зардлыг хохирогч хэд хоног байрласан эсэхээс үл хамааран нэг хүнд нэг удаа санхүүжилт олгохоор тооцно.

Жишээ: Түр хамгаалах байранд иргэн “Ж” хүүхэдтэйгээ хамт 20 хоног байрласан бөгөөд хүүхэд нь гэр бүлээс тусдаа орчинд үзүүлэх хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдаагүй гэж үзвэл түүнд шаардагдах санхүүжилт нь дараах байдалтай байна:

Бүрэлдэхүүн	Ээж	Хүүхэд
Хоолны хүнс	222,000	190,000
Ариун цэврийн багц	92,587	78,751
Нийгмийн ажлын багц	70,000	50,000
Дүн	384,587	318,571

Аргачлал: Дээрх жишээн дээр ээж буюу насанд хүрэгчийн зардал нийт 384,587 төгрөг болох бөгөөд энэ нь,

- 1/ хоолны зардал нь тарифт 11,100 төгрөг * 20 хоног = 222,000 төгрөг
- 2/ хувийн ариун цэврийн багц нь 20 хоносон тул 65.000 төгрөг /14 хоног*20 хоног=92,857 төгрөг болно
- 3/ нийгмийн ажлын зардал нэг удаагийн багц 70,000 төгрөг болно.

Гурав. Хувьсах зардлын санхүүжилт

3.1. Нэг хүнд ногдох санхүүжилтийг гүйцэтгэлээр нь тооцож санхүүжүүлнэ.

3.2. Түр хамгаалах байрны үйл ажиллагааны онцлог, бараа бүтээгдэхүүнийг урьдчилан хямд өртгөөр нөөцлөх шаардлага зэргийг харгалзан өмнөх жилд хамрагдсан хүний тоонд үндэслэн тухайн жилд хуваарилах нийт санхүүжилтийн 30 хувийг урьдчилан олгож болно.

3.3. Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хүний тоо анх тооцсон дунджаас хэтрэх, эсхүл дутах бол зөрүүг гүйцэтгэлээр нь тооцно.

3.4. Түр хамгаалах байранд байрласан хүүхдэд шаардагдах зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын гэр бүлээс тусдаа орчинд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний тарифаар тооцож олгосон бол санхүүжилтийг давхардуулан олгохгүй.

3.5. Тухайн түр хамгаалах байрны зардлыг санхүүжүүлэх үүрэг хүлээсэн төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, төрийн бус байгууллага нь энэ журмын 4.1-д заасны дагуу шаардагдах төсвийн тооцооллыг боловсруулж жилийн төсвийн саналдаа тусгаж, дээд шатны эсхүл асуудал хариуцсан байгууллагаар дамжуулж шийдвэрлүүлнэ.

Жишээ: Төрийн бус байгууллагын дэргэдэх түр хамгаалах байранд жилд 67 хүн нийт 610 ор хоног байрласан гэж үзвэл Түр хамгаалах байрны дараагийн жилийн санхүүжилтийн хэрэгцээ нь нийт 13,988,000 төгрөг болно

	Хүүхэд	Насанд хүрэгч	Нийт
Байрласан хүний тоо	38	29	67
Нийт ор хоног	430	180	610
Дундаж ор хоног	11.3	6.2	17.5
<i>Хоолны зардал</i>	<i>4,085,000</i>	<i>1,998,000</i>	<i>6,083,000</i>
<i>Ариун цэврийн зардал</i>	<i>2,090,000</i>	<i>1,885,000</i>	<i>3,975,000</i>
<i>Нийгмийн ажлын зардал</i>	<i>1,900,000</i>	<i>2,030,000</i>	<i>3,930,000</i>
Бүгд	8,075,000	5,913,000	13,988,000

Аргачлал:

1/ хоолны зардлыг дундаж ор хоногоор тооцох бөгөөд нийт ор хоногийн тоог байрласан хүний тоонд хувааж гаргана. Жишээн дээр хүүхэд дунджаар 11.3 хоног, насанд хүрэгч 6.2 байрласан бөгөөд дундаж ор хоногийг хоолны нэг өдрийн тарифаар үржүүлж тооцно.

2/ хувийн ариун цэврийн багц болон нийгмийн ажлын үйлчилгээний багцыг хохирогч хэд хоносноос үл хамааран нэг хүнд тус бүр нэг багц гэж тооцно

Дөрөв. Түр хамгаалах байрны бусад зардал

4.1. Хувьсах зардлын бүрэлдэхүүнд хамаарахгүй зардал, үйлчилгээг дараах байдлаар санхүүжүүлнэ:

4.1.1. “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (Монгол Улсын стандарт- MNS 6040:2019) заасан мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, тогооч, түүнчлэн жолооч, харуул хамгаалалт, халамжийн

ажилтан, эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Түр хамгаалах байрыг үүсгэн байгуулсан этгээд хариуцна;

4.1.2. Түр хамгаалах байрны цахилгаан эрчим хүч болон халаалт, засвар үйлчилгээний зардлыг түр хамгаалах байрыг үүсгэн байгуулсан этгээд хариуцна.

4.1.3. Хамгаалалтад байгаа хохирогчид үзүүлэх эрх зүйн туслалцаа, сэтгэл зүйн үйлчилгээг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18.2-т заасны дагуу мөн хуулийн 23.1-т заасан байгууллага үнэ төлбөргүй үзүүлнэ.

Тав. Санхүүжилт олгоход шаардах бичиг баримт

5.1. Хувьсах зардлын санхүүжилтийг хохирогчтой холбоотой дараах бичиг баримтыг үндэслэн олгоно:

5.1.1. нөхцөл байдлын үнэлгээ эсхүл аюулгүйн зэргийн үнэлгээ;

5.1.2. төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэхийн хуулбар;

5.1.3. үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өргөдөл.

5.2. Түр хамгаалах байранд байрлаж үйлчилгээнд хамрагдсан эсэхийг цахимаар баталгаажуулсан тохиолдолд бичиг баримт шаардахгүй байж болох бөгөөд зөвхөн санхүүтэй холбоотой нэхэмжлэхийг цахимаар илгээнэ.

5.3. Хохирогч оршин суух албан ёсны харьяаллын бус нутаг дэвсгэрийн түр хамгаалах байранд үйлчилгээ авсан бол түүний зардлыг тухайн түр хамгаалах байр байршиж байгаа нутаг дэвсгэрийг хариуцсан холбогдох төрийн байгууллагаас санхүүжүүлнэ. Энэ тохиолдолд зардлын санхүүжилтийг төрийн байгууллага хооронд цахимаар баталгаажуулалт болон зохицуулалт хийж шийдвэрлэх бөгөөд хохирогчтой холбоотой бичиг баримтыг давхардуулан шаардахгүй.

Зургаа. Хяналт ба хариуцлага

6.1. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамрагдсан хохирогчийн мэдээллийг тусгайлан кодлож нууцалсны дагуу гэр бүл, хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим санд /гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний мэдээллийн сан итусламж.мн/ бүртгэнэ.

6.2. Цахим санд дэх бүртгэл нь хохирогчийн ирсэн болон гарсан он, сар, өдөр, байрласан хоногийн тоо, авсан үйлчилгээний нэр төрөл, гэр бүлээс тусдаа орчинд хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулсан эсэх мэдээллийг агуулсан байна.

6.3. Хувьсах зардлын санхүүжилтийг цахим сангийн бүртгэлийн тайланг үндэслэн олгоно.

6.4. Гэр бүл, хүүхэд хамгааллын болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санхүүжилт хүлээн авсан болон олгосон байгууллагын үйл ажиллагаанд тусгайлан гаргасан хуваарьт төлөвлөгөөний дагуу бүртгэлийн болон санхүүжилтийн нарийвчилсан хяналтыг хэрэгжүүлнэ.

6.5. Зардлын санхүүжилт давхардуулан олгох, урьдчилгаа санхүүжилтийн хязгаарыг хэтрүүлэх, хохирогчийн бүртгэлийг хуурамчаар үйлдэж илүү санхүүжилт авах болон олгох, хохирогчийн хувийн мэдээллийн нууцлалыг задруулах, журамд зааснаас өөрөөр бичиг баримт бүрдүүлэхийг шаардах зэргээр энэхүү журамд заасныг зөрчсөн, түүнчлэн зөрчил гаргах боломж бүрдүүлсэн албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-oOo-

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд
ногдох хувьсах зардал тооцох журмын хавсралт

**ТҮР ХАМГААЛАХ БАЙРАНД БАЙРЛАХ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ
ЗАРДЛЫН НОРМАТИВ**

№	Хувьсах зардлын бүрэлдэхүүн		Давтамж	Тариф (төгрөг)
1	Хоол хүнс	Насанд хүрэгч	1 хүн /1 хоногт	11,100
		Хүүхэд		9,500
2	Хувийн ариун цэврийн хэрэгсэл	Насанд хүрэгч	Багц/нэг удаа	65,000
		Хүүхэд		55,000
3	Нийгмийн ажлын үйлчилгээ	Насанд хүрэгч	Багц/нэг удаа	70,000
		Хүүхэд		50,000